

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

## улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

**“1 дүгээр зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 26.4 дэх хэсэг нэмсүгэй:

“26.4.энэ хуулийн 26.2-т зааснаас бусад малыг гадаадад гаргах лиценз олгоход малын тоо толгой тутмаас дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

- 26.4.1. адуу 48 000-120 000 төгрөг;
- 26.4.2. үхэр 32 000-80 000 төгрөг;
- 26.4.3. хонь 19 200-48 000 төгрөг;
- 26.4.4. ямаа 19 200-48 000 төгрөг;
- 26.4.5. тэмээ 96 000-240 000 төгрөг.”

**2 дугаар зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дараахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/26 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт:

“26.3.2. малын үржүүлгийн бусад бүтээгдэхүүн 5 000-50 000 төгрөг”

2/35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 21 дэх заалт:

“35.1.21. малд удам гарвацийн болон эрүүл мэндийн гэрчилгээ, шилжилт хөдөлгөөний тодорхойлолт, мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээнд итгэмжлэлийн гэрчилгээ, мал, үржүүлгийн бүтээгдэхүүнд гарал үүслийн тодорхойлолт, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд чанарын гэрчилгээ олгоход 1000-5000 төгрөг.”

**3 дугаар зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 26.1.9 дэх заалтын “малын гүн хөлдөөсөн үр, хөврөл үрийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, үржлийн сайжруулагч мал импортлох, экспортлох” гэснийг “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.11.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх” гэж, 26.3 дахь хэсгийн “гүн хөлдөөсөн үр, хөврөл үр” гэснийг “үржүүлгийн бүтээгдэхүүнийг” гэж, “гаргахад” гэснийг “гаргах лиценз олгоход” гэж, 26.3.1 дэх заалтын “гүн хөлдөөсөн үр, хөврөл үр” гэснийг “үр, хөврөл” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.1.14, 35.1.19, 35.1.20 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар .....

Улаанбаатар  
хот

## ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Гаалийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” Улсын Их Хурлын 1998 оны 5 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол улсын хилээр тарифын бус бусад хязгаарлалттай нэвтрүүлэх бүлэг барааны жагсаалт”-ын 7, 9 дэх заалтыг хассугай.

2.Энэ тогтоолыг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ